

“Мандал говь-Импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл

2021-04-26

Дундговь аймаг

“Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цаг үеийн онцгой нөхцөл байдлын улмаас 2021 оны 4 дүгээр сар 26-ны өдрийн 15.00-16.00 цагийн хооронд Цахим хэлбэрээр хийлээ.

Хурлын дарга Ө.Будханд даргалав.

Хурлын дарга Ө.Будханд: Монгол Улсын компанийн тухай хуульд заасаны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг товолж өнөөдөр хурлаа хийх гэж байна. БДК-уудад хурлын материалыг хүргүүлсэн ба олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр хуульд заасан хугацаанд зарыг тавьсан. Одоо хурлын дэгийг танилцуулъя. Та бүхэн санал хүсэлт байна уу.

Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хурлын дэгийг баталлаа.

Нарийн бичгийн дарга С.Батбилэг хурлын ирцийг танилцулав.

С.Батбилэг: “Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцааны 52612 ширхэг хувьцааг эзэмшигч 3 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон ба 73,7 хувийн ирцтэй байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр заалтыг үндэслэн ирц хангалттай гэж үзээд хурлыг эхлүүлж байна.

Хурлаар хлэлцэх асуудлууд:

-Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

- Компанийн ТУЗ-ийн 2020 оны тайлан

- Аудитын хорооны тайлан

- ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлын дарга:Ө.Будханд Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааны тайланг компанийн менежер Ч.Уранбайгаль танилцуулна. /Хурлын материалд тайланг хавсаргав/

Хурлын дарга Ө.Будханд: Тайлантай холбоотой асуух тодруулах зүйл байвал асууя.

Д.Ганболд: Өнгөрсөн жилийн хувьд ч байдал тодорхой байна. Угийн орлого, үйл ажиллагаа муу байсан дээр нь Ковид гээд бүүр хэцүү болж байгаа юм байнадаа.

Ө.Будханд: Бид олсон бага сага орлогоороо боломжоороо өөрсдөө засвар үйлчилгээ хийгээд л явдаг. 2020 оны хувьд ч бас жоохон засвар үйлчилгээ хийсэн. Хуучны барилга болохоор нэг юмаа засахад нөгөө юм нь эвдэрч байх жишээний маш асуудалтай байна. Өнгөрсөн өвөл зогсонги байдалтай өнгөрлөө.

Хурлын дарга Ө.Будханд : ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

/Хурлын материалд тайланг хавсаргав/

Хурлын дарга Ө.Будханд : Аудитын хорооны тайланг танилцуул гэв.

Аудитын хорооны гишүүн С.Содбаатар Аудитын тайланг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав/

Хурлын дарга Ө.Будханд: Тайлангуудаа сонслоо. Асуулт хариулт байвал асууцгаая.

Д.Мөнхсайхан: Одоо ч ер нь хаа сайгүй хэцүү байна. Нэг л дорвитой шийд гаргахгүй бол Алтанговь буудал бас л нүсэр хэцүү хэцүү. ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэх хэрэгтэйн байна. Олон жил иймэрхүү үлгэн байдалтай явж байна.

Хурлын дарга Ө.Будханд: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг сонгоё. ТУЗийн гишүүдийн танилцуулгыг хийв.

Хурлын дарга Ө.Будханд: Хурлын дэгийн санал авсан байгаа. П.Мөнгөцэцэг саналын дүнгээ танилцуул гэв.

П.Мөнгөнцэцэг: Санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төслийг танилцуулав.

1. Саналын хуудсаал Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн байна.

2. ТУЗийн гишүүнд нэр дэвшигч Д.Хуушаан, Д.Ганболд, Д.Мөнхсайхан, А.Цэцэгдэлгэр, Ч.Тогтохбаяр, Ө.Будханд. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч С.Дарханбаатар, Э.Мөнхсайхан, С.Содбаатар нар 52612 ширхэг санал буюу 100 хувь тус тус санал авсан байна.

Хурлын дарга Ө.Будханд: "Мандалговь-Импекс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүдийг танилцуулж баталлаа.

1. Тогтоол №1 Тайлан батлах /2020 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайлан/

2. Тогтоол №2 ТУЗ-ийн гишүүдийг батлах

Хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа, та бүхэндээ эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хурлыг 16.00 цагт хаав.

Хянасан хурлын дарга

Ө.Будханд

Тэмдэглэл хөтөлсөн

С.Батбилэг